

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/10/СТА-ТӨХК

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3	Менежментийн захидал.....	15
3.1	Тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.....	15
3.2	Шилэн данстай холбоотой асуудал	16
3.3	Бараа материалын данстай холбоотой асуудал.....	17
3.4	Зардлын данстай холбоотой асуудал	18
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	20
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	20
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	21
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	22
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	23
4.5	Аудит хийсэн зорилтот түвшиний биелэлт	25
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	27

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН Г
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ Г
ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ Г
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА О.БАВУУДОРЖ Г
ТАНАА

2018 03.15 № 06/448
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


071125

Үүрэг, хариуцлага

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Бавуудорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Интер аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Дарамрагчаа, чанарын хяналтын менежер Ц.Хулан, аудитор Д.Базаргарам, аудиторын туслах С.Уртнасан, Д.Дэлгэрмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн №03/66 дугаар бүхий албан бичгээр “Интер аудит” ХХК-д ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь “Монгол Улсын зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтөч нь байх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа;
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар угсралт, туршилт тохируулга, бусад үйлчилгээ.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- ТӨБЗГ-ын 336 дугаар тогтоолоор хувьцааны тоог 66,923,651 ширхэгээр буюу 6,692,365,100 /Зургаан тэрбум зургаан зуун ерэн хоёр сая гурван зуун жаран таван мянга нэг зуу/ төгрөгөөр нэмэгдүүлж, 337,660,090 ширхэг хувьцаатай 100 төгрөгний нэрлэсэн үнэтэй 33,766,009,000 /Гучин гурван тэрбум долоон зуун жаран зургаан сая есөн мянга/ төгрөгийн дүрмийн сантай болсон.
- Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 335 дугаар тогтоолоор Эрчим хүчний компаниудын хувьцааг 100 хувь ТӨБЗГ эзэмшиж байсанг Эрчим хүчний яам 70 хувь, ТӨБЗГ 30 хувь эзэмшихээр шийдвэрлэсэн.
- Дээрх тогтоолоос хамаарч ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон. Үүнд:

Д/д	Төлөөлөл	Өмнө нь	Одоо
1	Эрчим хүчний яам	2	5
2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	2	1
3	Сангийн яам	1	0
4	Засгын газрын хэрэг эрхлэх газар	1	0
5	Хараат бус	3	3

- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах Ханги Мандал хилийн боомтыг Хятад улсаас цахилгаан худалдан авч цахилгаанаар хангах болсонтой холбоотойгоор Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос “Цахилгаан эрчим хүч импортлох” тусгай зөвшөөрөл авсан.
- Дэлхийн банкны санхүүжилтээр “Эрчим хүч-2” төсөл хэрэгжүүлэх ажил эхэлсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинээр боловсруулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр болсон.
- Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаал, ТӨБЗГ-ын 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 367 дугаар тогтоолын дагуу газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн байна.

Дахин үнэлгээгээр нийт 5 салбар болон компанийн хөрөнгийг дахин үнэлж 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр “Шонхор үнэлгээ аудит” ХХК-иар үнэлгээний нягтлан шалгалтын тайлан дүгнэлт гаргуулж 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, бүртгэлд тусган ажилласан байна.

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийхэд үндсэн хөрөнгийн тайланд гарсан өөрчлөлтийг хүснэгтээр харуулвал:

Дахин үнэлгээг бүртгэлд тусгахдаа дараах байдлаар тусгаж ажилласан байна.

/сая төгрөг/

Нэр	Нийт анхны үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өгрөг
Хөрөнгийг үнэлээгүй үед	73,855.6	29,891.4	43,964.3
Хөрөнгийг дахин үнэлэхэд	125,426.6	6,755.5	118,671.1
Зөрүү	51,570.9	-23,135.9	74,706.8

Газар

2050000XX00 Газар ба газрын эрх 1,713.9 сая
4110020XX00 Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг 1,713.9 сая

Газар нь өмчлөх бус эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээтэй тул биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна. Мөн газрыг анх удаа үнэлж бүртгэлд тусгаж байгаа учраас дахин үнэлгээний нэмэгдлээр бус эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансаар бүртгэсэн байна.

Санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дансны эхний үлдэгдэл 7,096.6 сая төгрөг байснаас тайлант онд дахин үнэлгээний өсөлт нь 73,295.7 сая төгрөг, дахин үнэлгээний бууралт нь 678.4 сая төгрөгөөр хэлбэлзэж дахин үнэлгээний нэмэгдлийн дансны эцсийн үлдэгдэл нь 79,713.9 сая төгрөг болсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын тайлант онд хүчин төгөлдөр мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэхгүй байна.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь СТОУС болон Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-д нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр болсон.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “FCS” програм хангамж ашигладаг байна.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд компанийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагналын ажлын зохион байгуулалт, байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитор тогтоосон материаллаг байдлыг тусгайлсан ажил гүйлгээ, дансанд тодруулгуудад хамааралтай эсвэл эрсдэл нь бүхэлдээ санхүүгийн тайлантай хамааралтай эсэхийг авч үзсэнтэй холбоотой юм.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 75,547.7 сая төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 151.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг судалж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд

тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн бус үйл ажиллагааны орлого болох цайны газрын орлогыг түрээсийн орлогоор андууран бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17 Түрээс “Түрээс гэдэг нь түрээслүүлэгч зөвшөөрсөн хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ тодорхой төлбөртэйгээр түрээслэгчид шилжүүлэх хэлцэл юм” гэж заасан байдаг.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” 15 “Санхүүгийн тайланд аж ахуй нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалттай нийцэхгүй учир залруулга хийсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	51.1	
	Дүн	4	51.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад төлбөрийн акт тогтоосон, албан шаардлага өгсөн, сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн, хууль хяналтын байгуулллагад асуудлыг шилжүүлсэн зэрэг асуудал гараагүй бөгөөд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулсан.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дугаар зүйлд заасан “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгах.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 13 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 65,721.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг харуулав.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он			Зорилтоос	
			Төлөв	Зорилт	Гүйцэтгэл	дүн	хувь
1	Худалдан авсан ЦЭХ	сая кВт*ц	350.5	350.5	410.5	60.0	117.1%
2	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	9.00%	9.00%	6.84%	-2.16%	76.0%
	биетээр	сая кВт*ц	31.5	31.5	28.1	-3.5	89.0%
3	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	318.9	318.9	382.4	63.5	119.9%
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	158.8	158.8	157.5	-1.3	99.2%
4	Нийт орлого	сая төг	65,721.5	65,721.5	75,670.9	9,949.3	115.1%
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	50,644.0	50,644.0	60,248.1	9,604.1	119.0%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	14,614.2	14,614.2	14,614.2	0.0	100.0%
	Импортын /Сэргээгдэх/ эрчим хүчний орлого	сая төг	0.0	0.0	8.4	8.4	0.0%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	463.3	463.3	800.1	336.8	172.7%
5	Нийт зардал	сая төг	65,487.4	65,487.4	75,547.7	10,060.3	115.4%
	Үүнээс:Худалдан авсан эрчим хүчний зардал	сая төг	48,671.5	48,671.5	58,311.1	9,639.6	119.8%
	ХУА ЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	138.9	138.9	142.1	3.2	102.3%
	Түгээх ажиллагааны зардал	сая төг	16,614.1	16,614.1	16,545.5	-68.5	99.6%
	Импортын /Сэргээгдэх/ эрчим хүчний зардал	сая төг	0.0	0.0	17.9	17.9	0.0%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	201.8	201.8	673.2	471.3	333.5%
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	234.1	234.1	123.1	-111.0	52.6%
	Орлогын албан татвар	сая төг	0.0	0.0	118.4	118.4	0.0%
7	Цэвэр ашиг, алдагдал	сая төг	234.1	234.1	4.7	-229.4	2.0%
8	Төрийн өмчийн ногдол ашиг	сая төг	77.6	77.6	338.1	260.5	435.7%
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	0.0	100.2%
10	Нийт авлага	сая төг	1,006.8	1,400.0	721.1	-678.9	51.5%

	Үүнээс: ЦЭХ-ний авлага	сая төг	921.3	1200.0	467.6	-732.4	39.0%
	ДҮТ-ийн авлага	сая төг	2.7	0.0	0.0	0.0	0.0%
	НӨАТ-ын авлага	сая төг	76.0	0.0	140.7	140.7	0.0%
	Бусад авлага	сая төг	6.8	0.0	112.8	112.8	0.0%
	Нийт өр төлбөр	сая төг	1,596.6	1,635.0	2,461.6	826.6	150.6%
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	1,582.7	1,620.0	2,195.5	575.5	135.5%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	1,490.5	1,500.0	1,947.6	447.6	129.8%
11	БН-ийн өглөг	сая төг	18.9	0.0	27.7	27.7	0.0%
	ДҮТ-ийн өглөг	сая төг	0.0	0.0	16.7	16.7	0.0%
	Урт хугацаат өрийн өглөг	сая төг	1.1	0.0	108.6	108.6	0.0%
	ЦЭХ-ний УТТ	сая төг	72.2	120.0	94.8	-25.2	79.0%
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	3,278.7	3,278.7	2,476.9	-801.8	75.5%
Үүнээс	Хөрөнгө оруулалт	сая төг	730.5	730.5	749.0	18.5	102.5%
	Их засвар	сая төг	432.4	432.4	460.8	28.4	106.6%
	ТЗБАХ	сая төг	1293.2	1293.2	1267.1	-26.1	98.0%
13	Нийт ажиллагсдын тоо	хүн	529	529	527	-2	99.6%
	Нийт цалингийн сан	сая төг	9,084.1	9,084.1	9,051.4	-32.7	99.6%

2018 оны тайлан тэнцлийн дүнгээр батлагдсан зорилтот түвшний 13 үзүүлэлтүүдээс 12 үзүүлэлтүүдийг биелүүлж ажилласан байна. Үүнд:

1. Худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 60.0 сая кВт*ц-аар илүү буюу 117.1 хувиар;
2. ЦЭХ-ний түгээлтийн нийт алдагдал 6.84 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 2.16 нэгжээр буурсан;
3. Борлуулсан цахилгаан эрчим хүчний төлөвлөгөөг 63.5 сая кВт*ц-аар илүү буюу 119.9 хувиар;
4. Нийт 75,670.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөнөөс 9,949.3 сая төгрөгөөр илүү буюу 115.1 хувиар;
5. Нийт 75,547.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс 10,060.3 сая төгрөгөөр илүү, үүнээс түгээх үйл ажиллагааны зардлыг 68.5 сая төгрөгөөр хэмнэж, худалдан авсан ЦЭХ-ний зардал 9,639.6 сая төгрөгөөр хэтэрсэн;
6. ТТӨ нийт 123.1 сая төгрөгийн ашигтай;
7. ТТД нийт 4.7 сая төгрөгийн цэвэр ашигтай;
8. Төрийн өмчийн ногдол ашигт 338.1 сая төгрөгийг төлсөн;
9. Борлуулалтын 1 төгрөгт 1.0 мөнгөний зардалтай;
10. Нийт авлагыг оны эхнээс 294.8 сая төгрөгөөр буюу 29.2 хувиар бууруулсан;
11. Нийт өр төлбөр оны эхнээс 865.0 сая төгрөгөөр буюу 54.2 хувиар өссөн;
12. Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлаар 95 нэр төрлийн, нийт 2,476.9 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн;

13. Батлагдсан орон тоо 529, гүйцэтгэлээр 527 орон тоотой ажиллаж, нийт цалингийн сангийн зардалд 9,051.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртгийн талаар:

Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулагчдын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 479 дүгээр тогтоолоор “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас худалдаж авах цахилгааны тарифыг 161.31 төг/кВт*цагаар баталж, өмнөх тарифаас дундажаар 21.54 төг/кВт*цагаар нэмэгдүүлсэнээр худалдан авсан цахилгаан эрчим хүчний зардал 859.4 сая төгрөгөөр нэмэгдэж, ашгийн хэмжээ 859.4 сая төгрөгөөр буурсан байна.

2018 оны эхэнд нэг худалдан авагчид төлөх цахилгаан эрчим хүчний өглөг 1,490.5 сая төгрөг байсан бөгөөд оны эцэст 1,088.2 сая төгрөг болон буурах боломжтой байсан боловч эрчим хүчний тарифыг нэмэгдүүлсэнээр худалдан авсан цахилгаан эрчим хүчний өглөг 859.4 сая төгрөгөөр нэмэгдэж, нэг худалдан авагчид төлөх цахилгаан эрчим хүчний өглөг оны эхнээс 457.1 сая төгрөгөөр нэмэгдэж 1,947.6 сая төгрөг болоход нөлөөлсөн.

“Багануурын дулааны станц” ТӨХК-д дундаж үнийн хөнгөлөлт үзүүлсэн талаар:

2018 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд нийт борлуулсан эрчим хүчний дундаж үнэ кВт*ц тутамд 157.54 төгрөг буюу төлөвлөгөөнөөс 1.21 төгрөгөөр буурч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 3.0 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Дундаж үнэ төлөвлөсөн хэмжээнээс буурсан нь Багануур цахилгаан түгээх сүлжээ салбарын томоохон хэрэглэгч болох “Багануурын дулааны станц” ТӨХК-д борлуулах ЦЭХ-ний тарифыг ЭХЗХ-ны 192 дугаар тогтоолоор 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дунджаар 70.67 төг/кВт*ц-аар, сэргээгдэх эрчим хүчний тарифыг 6.53 төг/кВт*ц-аар, чадлын тарифыг 4,950 төг/кВт/сар-аар тус тус бууруулсан нь компанийн дундаж үнийг 0.9 төг/кВт*ц-аар, Багануур салбарын дундаж үнийг 4.61 төг/кВт*ц-аар тус тус буурахад нөлөөлсөн.

Энэхүү тарифын хөнгөлөлтөөр нийт 341.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг “Багануурын дулааны станц” ТӨХК-д үзүүлсэн бөгөөд энэ хэмжээгээр борлуулалтын орлого буурсан байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд “Багануурын дулааны станц” ТӨХК-иас авах авлага 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 339.6 сая төгрөг байсан бол 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өр авлагагүй болсон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь 2018 оны зорилтот түвшин, бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан мөнгөн урсгал, орлого, зардал, удирдлагын шийдвэр, санхүүжилт, тендер шалгаруулалт, худалдан авалт, тохиолдсон голлох үйл явдал, онцлог ажил гүйлгээний талаарх мэдээллийг <http://shilendans.gov.mn/org/5167> сайтад оруулж олон нийтэд толилуулж байна.

Тус компанийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 70 нэр төрлийн 3,922.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Төлөвлөгдсөн ажлуудаас нээлттэй тендер шалгаруулалтаар 17 ажил, харьцуулалтын тендер шалгаруулалтаар 36 ажил, гэрээ шууд байгуулахаар 10 ажил, зөвлөх үйлчилгээний 7 ажлын гүйцэтгэлийг байрлуулсан байна.

Нийт шилэн дансанд байрлуулах явцын мэдээллээс харахад 1 дүгээр сарын шивэлтийг хугацаа хоцроосон байна.

Мөн шилэн дансны сайтад худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг оруулсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж үзэхэд мэдээллийг оруулаагүй, дутуу шивсэн, гэрээний дүнг зөрүүтэй шивсэн зэрэг тохиолдлууд илэрч байна. Үүнд:

- Говьсүмбэр салбар 35/6 кВ Шивээговь дэд станц ТП-55, 57, 59, Хонгор дэд станц ТП-1, 3, 7 дээвэр засварлах тендерт “Их гүн констракшн” ХХК шалгарч 20.4 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан байна. Тус гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 20.5 сая төгрөгөөр байгуулсан гэж буруу байрлуулсан.
- Говьсүмбэр салбар Донгни автокраны мотор солих, Дорноговь салбар 47-99 БРА Пикап автомашинд засвар хийх тендерт “Аготем” ХХК шалгарч 16.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан. Тус гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 22.0 сая төгрөгөөр байгуулсан гэж буруу байрлуулсан.
- Стандарт дүрэм журмууд, нэг маягийн ажлын зургууд тендерт “ЭХХХ” ХХК шалгарч 10.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан. Тус гэрээний дүнг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулаагүй байна.
- “БЗӨБЦТС” ТӨХК-ийн 3 дугаар давхарын 301 дүгээр өрөөний их засвар ХАН№18/27 дугаар бүхий тендерт “Эко Монгол экьюпмент” ХХК шалгарч 17.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй.
- Трансформаторын тос Багц№01 НТШ18/07 дугаар бүхий тендерт “Таван тайхар” ХХК шалгарч 9.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” зэргийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах хэрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагааны талаар 1 зөвлөмж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаар 1 зөвлөмж, ногдол ашгийн талаар 1 зөвлөмж, үндсэн хөрөнгийг бараа материалын дансаар дамжуулж бүртгэсэн талаар 1 зөвлөмж, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар 1 зөвлөмж, нийт 5 зөвлөмж өгсөнийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1.1 Илрүүлэлт:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үнэлгээний хорооны нэг гишүүний АЗ сертификатын хугацаа 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр дууссан байхад үнэлгээний хороонд орж ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д “*үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.1.2 Эрсдэл:

Үнэлгээний хороонд хууль, журмын дагуу зохих зөвшөөрөл аваагүй ажилтан ажиллах эрсдэлтэй.

3.1.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.1.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.1.2.1 Илрүүлэлт:

Шатахуун АИ92, АИ80, ДТ, тос, тослох материал НТШ№18/06 дугаартай тендер “НИК” ХХК шалгарч 236.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулсан байна. Тус гэрээг зохих баримтанд хавсаргаж архивлаагүй байна.

3.1.2.2 Эрсдэл:

Холбогдох дэмжих, нотлох баримтын дагуу хийгдээгүй нөхцөлд бүртгэл, тайлан алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.1.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны баримт материалуудыг бүрэн бүрдүүлж архивлах мөн архивлаж буй баримт материалуудыг бүрдэлийг шалгаж, баримтжуулж байх зөвлөмж өгөв.

3.1.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн данстай холбоотой асуудал

3.2.1.1 Илрүүлэлт:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн компаниудын гэрээний дүнг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зөрүүтэй байрлуулсан. Үүнд:

- Говьсүмбэр салбар 35/6 кВ Шивээговь дэд станц ТП-55, 57, 59, Хонгор дэд станц ТП-1, 3, 7 дээвэр засварлах тендерт “Их гүн констракшн” ХХК шалгарч 20.4 сая төгрөгийн дүн бүхий гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 20.5 сая төгрөгөөр байрлуулж 0.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.
- Говьсүмбэр салбар Донгни автокраны мотор солих, Дорноговь салбар 47-99 БРА Пикап автомашинд засвар хийх тендерт “Аготем” ХХК шалгарч 16.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 22.0 сая төгрөгөөр байгуулж 6.0 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.
- Стандарт дүрэм журмууд, нэг маягийн ажлын зургууд тендерт “ЭХХХ” ХХК шалгарч 10.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан боловч тус гэрээний дүнг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулаагүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн тус хуулийн 7 дугаар зүйлийн “мэдээлэх албан тушаалтан” гэж 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.1.2 Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгч нарт алдаатай хүргэх, өндөр өртөг, үнээр хийгдсэн худалдан авалт, бараа ажил үйлчилгээ бага зардал, санхүүжилтээр хийгдсэн мэтээр төөрөгдүүлэх эрсдэлтэй.

3.2.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.2.2.1 Илрүүлэлт:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн дараах компаниудын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулаагүй байна. Үүнд:

- “БЗӨБЦТС” ТӨХК-ийн 3 дугаар давхарын 301 дүгээр өрөөний их засвар ХАН№18/27 дугаар бүхий тендерт “Эко Монгол экьюпмент” ХХК шалгарч 17.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй.
- Трансформаторын тос Багц№01 НТШ18/07 дугаар бүхий тендерт “Таван тайхар” ХХК шалгарч 9.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 1.1-д “улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино”, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” зэргийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулж байх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.2.2.2 Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгч нарт алдаатай хүргэх, өндөр өртөг, үнээр хийгдсэн худалдан авалт, бараа ажил үйлчилгээ бага зардал, санхүүжилтээр хийгдсэн мэтээр төөрөгдүүлэх эрсдэлтэй.

3.2.2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулж байх зөвлөмж өгөв.

3.2.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.3.1.1 Илрүүлэлт:

“Гал импекс” ХХК-иас 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 0.3 сая төгрөгийн галын булангийн багц худалдан авч орлогод авахдаа НӨАТ-тэй дүнгээр бүртгэн өртгийг буруу илэрхийлсэн байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.1-д заасны дагуу “Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хассан дүнгээр бараа, материалын дансанд бүртгэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.1.2 Эрсдэл:

Бараа материалын өртөг буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайланг буруу тайлагнах.

3.3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг бэлтгэн нийлүүлэгчийн баримтыг үндэслэн зөв дүнгээр бүртгэлд тусгаж байх зөвлөмж өгөв.

3.3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.3.2.1 Илрүүлэлт:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь дараах нэр төрлийн бараа материалуудыг орлогод бүртгэхдээ нэр төрөл болон тоо хэмжээ, нэгжийн үнийг буруу бүртгэсэн байна.

- 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Хосбаяр гэдэг хувь хүнээс 2 ширхэг чагтан голыг 0.2 сая төгрөгөөр худалдан авсан байна. Тус чагтан голыг 2018 оны 02 сарын 28-ны өдөр орлогод бүртгэхдээ бууралттай хальс нэр төрлөөр андууран бүртгэсэн байна.
- 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Сийл жет Монголиа” ХХК-иас тус бүр 0.1 сая төгрөгийн үнэ бүхий нийт 4 ширхэг сальник худалдан авч орлогод бүртгэсэн байна. Тус бараа материалыг орлогод авахдаа 0.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг сальник гэж буруу бүртгэсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан “*үнэн зөв байх*” зарчим мөн НББОУС 2 бараа материал, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 9 дүгээр бүлгийн 9.4 бараа материал үнэ бүхий зүйлсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимуудтай нийцэхгүй байна.

3.3.2.2 Эрсдэл:

Бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хүлээн авсан огноо, тоо ширхэгээр нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нөхцөлд эзэнгүйдэх, орхигдох, хэрэгцээгүй болох эрсдэлтэй.

3.3.2.3 Өгсөн зөвлөмж:

Аливаа хөрөнгө, бараа материалын орлого, зарлагын гүйлгээг тухайн аж ахуйн үйл явдал хэрэгжсэн өдрөөр санхүүгийн программд бүртгэж, анхан шатны баримтыг бүрдүүлж байх зөвлөмж өгөв.

3.3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1.1 Илрүүлэлт:

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь гарын үсэг, тамгагүйгээр 6.9 сая төгрөгийн өртөг бүхий бараа материалын орлого, зарлагын гүйлгээг хийсэн байна. Анхан шатны баримтын бүрдэл дутуу гэж үзэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.5-д “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан*

ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.4.1.2 Эрсдэл:

Бараа материал дутагдах, санхүүгийн тайлан, мэдээллийг буруу тайлагнах.

3.4.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдэлийг ханган ажиллах зөвлөмж өгөв.

3.4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	2018.01.01	2018.12.31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	300,831,331.08	754,833,710.42
Дансны авлага	923,978,620.44	467,635,104.50
Татвар, НДШ-ийн авлага	75,994,594.53	220,738,216.69
Бусад авлага	6,819,902.30	23,593,306.90
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	1,003,531,563.37	915,690,500.76
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		-
Бусад эргэлтийн хөрөнгө	39,076,000.00	43,634,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,350,232,011.71	2,426,124,839.27
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	43,773,890,190.39	116,820,371,156.14
Биет бус хөрөнгө	45,272,827.76	1,850,746,161.92
Хойшлогдсон татварын хөрөнгө	18,425,270.02	24,757,324.60
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	43,837,588,288.17	118,695,874,642.66
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	46,187,820,299.88	121,121,999,481.93
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,490,542,886.76	1,964,357,765.18
Татварын өглөг		115,871.00
Банкны богино хугацаат зээл		
Урьдчилж орсон орлого	72,169,315.93	94,772,671.88
Бусад богино хугацаат өр төлбөр	18,901,825.10	27,708,792.75
Урт хугацаат өрийн тайлант үеийн өглөг	1,073,706.06	108,560,257.06
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,582,687,733.85	2,195,515,357.87
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	13,958,178.53	266,103,303.47
Бусад урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өглөг		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	13,958,178.53	266,103,303.47
Өр төлбөрийн дүн	1,596,645,912.38	2,461,618,661.34
Эзэмшигчдийн өмч ба капитал		
Төрийн өмч	27,073,643,900.00	33,766,009,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,096,603,438.25	79,713,939,127.04
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,692,365,183.61	1,843,205,083.61
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,728,561,865.65	3,337,227,609.94
Тайлант үеийн		
Өмнөх үеийн		
Эзэмшигчдийн өмч ба капиталын дүн	44,591,174,387.51	118,660,380,820.59
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	46,187,820,299.89	121,121,999,481.93

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого /цэвэр/	62,356,922,122.19	74,870,722,842.94
Борлуулалтын өртөг	58,729,228,033.84	71,548,858,672.07
Нийт ашиг /алдагдал/	3,627,694,088.35	3,321,864,170.87
Түрээсийн орлого	13,911,587.15	
Хүүгийн орлого	33,234,452.35	68,929,828.51
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	676,967,175.50	710,292,419.29
Борлуулалт, маркетингийн зардал	2,598,150,400.66	2,763,255,611.63
Ерөнхий ба удирдлагын зардал	511,555,796.09	562,438,593.59
Санхүүгийн зардал		
Бусад зардал	392,890,734.47	451,197,561.28
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-81,889,622.70	-201,075,914.68
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	767,320,749.43	123,118,737.49
Орлогын татварын зардал	157,654,457.31	118,403,102.11
Татварын дараах ашиг (алдагдал)	609,666,292.12	4,715,635.38
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	609,666,292.12	4,715,635.38
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	27,073,643,900.00	7,114,104,861.99	3,338,450,436.24	3,175,215,653.79	40,701,414,852.02
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				578,496.00	578,496.00
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				609,666,292.11	609,666,292.11
Бусад дэлгэрэнгүй орлого			3,353,914,747.37		3,353,914,747.37
Өмчид гарсан өөрчлөлт					0.00
Зарласан ногдол ашиг				-74,400,000.00	-74,400,000.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-17,501,423.74		17,7501,423.74	0.00
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	27,073,643,900.00	7,096,603,438.25	6,692,365,183.61	3,728,561,865.64	44,591,174,387.50
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-72,894,328.60	-72,894,328.60
Тайлант үеийн ашиг, алдагдал				4,715,635.38	4,715,635.38
Бусад дэлгэрэнгүй орлого			1,843,205,000.00		1,843,205,000.00
Өмчид гарсан өөрчлөлт	6,692,365,100.00		-6,692,365,100.00		0.00
Зарласан ногдол ашиг				-338,066,630.00	-338,066,630.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		72,617,335,688.79		14,911,067.52	72,632,246,756.31
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	33,766,009,000.00	79,713,939,127.04	1,843,205,083.61	3,337,227,609.94	118,660,380,820.59

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	47,049,336,862.12	47,049,336,862.12
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	45,584,040,731.62	57,198,547,284.75
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	103,039,707.02	74,934,738.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	1,362,256,423.48	893,852,028.31
Мөнгөн зарлагын дүн (-)	44,500,809,680.83	54,619,250,909.65
Ажиллагчдад төлсөн	7,998,652,074.23	8,531,129,461.37
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,009,238,671.00	2,322,749,492.37
Бараа материал худалдан авахад төлсөн	29,890,478,992.04	38,949,228,147.01
Ашиглалтын зардалд төлсөн	391,993,498.06	435,061,279.51
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	663,743,864.00	598,730,383.76
Хүүний төлбөрт төлсөн		239,285.34
Татварын байгууллагад төлсөн	2,442,369,080.30	2,591,548,949.72
Даатгалын төлбөрт төлсөн	19,781,678.00	55,538,861.45
Бусад мөнгөн зарлага	1,084,551,823.20	1,135,025,049.12
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,548,527,181.29	3,548,083,141.41
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	33,234,452.35	68,228,723.85
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	33,234,452.35	68,228,723.85
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	3,032,917,991.08	2,823,169,149.85
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,032,917,991.08	2,823,169,149.85
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,999,683,538.73	-2,754,940,426.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	1,190,268,285.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		1,190,268,285.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	75,473,706.06	1,529,408,621.06
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,073,706.06	1,191,341,991.06
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	74,400,000.00	338,066,630.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-75,473,706.06	-339,140,336.06
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-526,630,063.50	454,002,379.35
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	827,461,394.57	300,831,331.07
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,831,331.07	754,833,710.42

4.5 Аудит хийсэн зорилтот түвшиний биелэлт

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он			Зорилтоос	
			Төлөв	Зорилт	Гүйцэтгэл	дүн	хувь
1	Худалдан авсан ЦЭХ	сая кВт*ц	350.5	350.5	410.5	60.0	117.1%
2	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	9.00%	9.00%	6.84%	-2.16%	76.0%
	биетээр	сая кВт*ц	31.5	31.5	28.1	-3.5	89.0%
3	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	318.9	318.9	382.4	63.5	119.9%
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	158.8	158.8	157.5	-1.3	99.2%
4	Нийт орлого	сая төг	65,721.5	65,721.5	75,670.9	9,949.3	115.1%
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	50,644.0	50,644.0	60,248.1	9,604.1	119.0%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	14,614.2	14,614.2	14,614.2	0.0	100.0%
	Импортын /Сэргээгдэх/ эрчим хүчний орлого	сая төг	0.0	0.0	8.4	8.4	0.0%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	463.3	463.3	800.1	336.8	172.7%
5	Нийт зардал	сая төг	65,487.4	65,487.4	75,547.7	10,060.3	115.4%
	Үүнээс: Худалдан авсан эрчим хүчний зардал	сая төг	48,671.5	48,671.5	58,311.1	9,639.6	119.8%
	ХУА ЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	138.9	138.9	142.1	3.2	102.3%
	Түгээх ажиллагааны зардал	сая төг	16,614.1	16,614.1	16,545.5	-68.5	99.6%
	Импортын /Сэргээгдэх/ эрчим хүчний зардал	сая төг	0.0	0.0	17.9	17.9	0.0%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	201.8	201.8	673.2	471.3	333.5%
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	234.1	234.1	123.1	-111.0	52.6%
	Орлогын албан татвар	сая төг	0.0	0.0	118.4	118.4	0.0%
7	Цэвэр ашиг, алдагдал	сая төг	234.1	234.1	4.7	-229.4	2.0%
8	Төрийн өмчийн ногдол ашиг	сая төг	77.6	77.6	338.1	260.5	435.7%
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	0.0	100.2%
10	Нийт авлага	сая төг	1,006.8	1,400.0	721.1	-678.9	51.5%
	Үүнээс: ЦЭХ-ний авлага	сая төг	921.3	1200.0	467.6	-732.4	39.0%
	ДҮТ-ийн авлага	сая төг	2.7	0.0	0.0	0.0	0.0%
	НӨАТ-ын авлага	сая төг	76.0	0.0	140.7	140.7	0.0%

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

	Бусад авлага	сая төг	6.8	0.0	112.8	112.8	0.0%
	Нийт өр төлбөр	сая төг	1,596.6	1,635.0	2,461.6	826.6	150.6%
11	Богино хугацаат өр төлбөр	сая төг	1,582.7	1,620.0	2,195.5	575.5	135.5%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	1,490.5	1,500.0	1,947.6	447.6	129.8%
	БН-ийн өглөг	сая төг	18.9	0.0	27.7	27.7	0.0%
	ДҮТ-ийн өглөг	сая төг	0.0	0.0	16.7	16.7	0.0%
	Урт хугацаат өрийн өглөг	сая төг	1.1	0.0	108.6	108.6	0.0%
	ЦЭХ-ний УТТ	сая төг	72.2	120.0	94.8	-25.2	79.0%
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	3,278.7	3,278.7	2,476.9	-801.8	75.5%
Үүнээс	Хөрөнгө оруулалт	сая төг	730.5	730.5	749.0	18.5	102.5%
	Их засвар	сая төг	432.4	432.4	460.8	28.4	106.6%
	ТЗБАХ	сая төг	1293.2	1293.2	1267.1	-26.1	98.0%
13	Нийт ажиллагсдын тоо	хүн	529	529	527	-2	99.6%
	Нийт цалингийн сан	сая төг	9,084.1	9,084.1	9,051.4	-32.7	99.6%

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
				САГ-2019/10/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК			Сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
<p>“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн компаниудын гэрээний дүнг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зөрүүтэй байрлуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Говьсүмбэр салбар 35/6 кВ Шивээговь дэд станц ТП-55, 57, 59, Хонгор дэд станц ТП-1, 3, 7 дээвэр засварлах тендерт “Их гүн констракшн” ХХК шалгарч 20.4 сая төгрөгийн дүн бүхий гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 20.5 сая төгрөгөөр байрлуулж 0.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Говьсүмбэр салбар Донгни автокраны мотор солих, Дорноговь салбар 47-99 БРА Пикап автомашинд засвар хийх тендерт “Аготем” ХХК шалгарч 16.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 22.0 сая төгрөгөөр байгуулж 6.0 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Стандарт дүрэм журмууд, нэг маягийн ажлын зургууд тендерт “ЭХХХ” ХХК шалгарч 10.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан боловч тус гэрээний дүнг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулаагүй байна. <p>Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн тус хуулийн 7 дугаар зүйлийн “мэдээлэх албан тушаалтан” гэж 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн</p>	16.2	Зөвлөмж	Худалдан авах ажиллагааны хангамжийн албаны дарга	П.Ганбаяр

<p>даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.</p>				
<p>“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн дараах компаниудын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулаагүй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “БЗӨБЦТС” ТӨХК-ийн 3 дугаар давхарын 301 дүгээр өрөөний их засвар ХАН№18/27 дугаар бүхий тендерт “Эко Монгол экьюпмент” ХХК шалгарч 17.0 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй. • Трансформаторын тос Багц№01 НТШ18/07 дугаар бүхий тендерт “Таван тайхар” ХХК шалгарч 9.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулж ажил гүйцэтгэсэн байна. Тус компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудсанд байрлуулаагүй. <p>Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 1.1-д “улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино”, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” зэргийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулж байх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.</p>	<p align="center">27.0</p>	<p align="center">Зөвлөмж</p>		
<p>“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь гарын үсэг, тамгагүйгээр 6.9 сая төгрөгийн өртөг бүхий бараа материалын орлого, зарлагын гүйлгээг хийсэн байна. Анхан шатны баримтын бүрдэл дутуу гэж үзэж байна.</p>	<p align="center">6.9</p>	<p align="center">Зөвлөмж</p>	<p align="center">Ерөнхий нягтлан бодогч</p>	<p align="center">Т.Болдсанаа</p>

<p>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “<i>Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно</i>”, 13.5-д “<i>Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна</i>”, 13.7-д “<i>Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно</i>” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.</p>				
<p>“Гал импекс” ХХК-иас 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 0.3 сая төгрөгийн галын булангийн багц худалдан авч орлогод авахдаа НӨАТ-тэй дүнгээр бүртгэн өртгийг буруу илэрхийлсэн байна.</p> <p>Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.1-д заасны дагуу “<i>Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хассан дүнгээр бараа, материалын дансанд бүртгэх</i>” гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>	0.3	Зөвлөмж		
<p>“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь дараах нэр төрлийн бараа материалуудыг орлогод бүртгэхдээ нэр төрөл болон тоо хэмжээ, нэгжийн үнийг буруу бүртгэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Хосбаяр гэдэг хувь хүнээс 2 ширхэг чагтан голыг 0.2 сая төгрөгөөр худалдан авсан байна. Тус чагтан голыг 2018 оны 02 сарын 28-ны өдөр орлогод бүртгэхдээ бууралттай хальс нэр төрлөөр андууран бүртгэсэн байна. • 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Сийл жет Монголиа” ХХК-иас тус бүр 0.1 сая төгрөгийн үнэ бүхий нийт 4 ширхэг сальник худалдан авч орлогод бүртгэсэн байна. Тус бараа материалыг орлогод авахдаа 0.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг сальник гэж буруу бүртгэсэн байна. <p>Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан “<i>үнэн зөв байх</i>” зарчим мөн НББОУС 2 бараа</p>	0.7	Зөвлөмж		

материал, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 9 дүгээр бүлгийн 9.4 бараа материал үнэ бүхий зүйлсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимуудтай нийцэхгүй байна.				
<p>“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үнэлгээний хорооны нэг гишүүний А3 сертификатын хугацаа 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр дууссан байхад үнэлгээний хороонд орж ажилласан байна.</p> <p>Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д “<i>үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна</i>” гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>		Зөвлөмж	Худалдан авах ажиллагааны хангамжийн албаны дарга	П.Ганбаяр
Шатахуун АИ92, АИ80, ДТ, тос, тослох материал НТШ№18/06 дугаартай тендерт “НИК” ХХК шалгарч 236.9 сая төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулсан байна. Тус гэрээг зохих баримтанд хавсаргаж архивлаагүй байна.		Зөвлөмж		
Нийт дүн	51.1			

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.